

Түүх 3 : Иерусалимд ирсэн нь

Библийн эшлэл
[Марк11:10]

Эцэг Давидын маань айсуй хаанчлал ерөөлтэй ээ! Хамгийн дээдэд Хосанна!
гэж хашхиралдаж байлаа.

Израильд дээгүүр өнгөрөх баяр ойртон ирэв. Эрт үед Бурхан Мосегоор дамжуулан Израильчуудыг Египетийн дарлалаас гарган аварч байсан өдрийг “Дээгүүр өнгөрөх баяр” хэмээн тэмдэглэдэг байв.

Энэ баяр болоход тэд Иерусалимын сүмд цуглардаг байв. Есүс ч бас “Дээгүүр өнгөрөх баяр”-ыг тохиолдуулан Иерусалим руу явав. Маш олон хүмүүс энэ баярыг тэмдэглэхийн тулд Иерусалимд цуглардагч харин Есүсийн хувьд өөр нэгэн шалтгаантай байлаа. Есүс шавь нартаа ингэж хэлэв.

“Хажуугийн тосгонд очвол илжигний дудран байгаа. Түүнийг хөтлөн авчир. Хэн нэгэн яах гэж байгааг асуувал Эзэнд хэрэгтэй байна гэж хэлээрэй.” Дагалдагч нар нь өөрсдийнхөө гадуур хувцасыг дудрангийн нуруун дээр тохон түүн дээр Есүсийг суулгав. Хамгийн дээд Бурханы Хүү Есүс ингэж маш дорд төрхөөр Иерусалим руу явав. Олон хүмүүс найлзуур модны мөчир барьсаар хашгирцгаав.

Хосанна, Давидын удам Есүс ээ, биднийг аварч хайрла. Хүмүүс Есүсийг хүндэтгэн угтаж өөрсдийнхөө хувцасыг тайлан дудран унан ирж байгаа газар дэвсэж дээгүүр нь явуулав. “Хосанна хамгийн дээд Нэгэн, алдарыг авагтун!”

Хүмүүс яг л хааныг угтаж байгаа юм шиг Есүсийг угтан авав.

Есүсийн дагалдагч нар ч мөн өөр хоорондоо шивэр авир хийж байв.

Харин Есүс, хүмүүсийн ярьж байгаа зүйл нь удаан үргэлжлэхгүй гэдгийг мэдэж байлаа.

Есүс дэлхийн алдар нэрийг олохын тулд бус Бурханы улсын төлөө хийж байсан юм.

Гэм нүгэлтэй хүмүүсийн төлөө, модон загалмайд цовдлогдохын тулд Иерусалим дахь сүмийг чиглэн байлаа. Есүс Иерусалимийн ойр хавийг анхааралтай харсаар ариун сүмийн зүг явав.

Ариун сүмд ороод Есүс маш их гайхлаа. Тэнд худалдаачидаар дүүрсэн байв. Есүс худалдаачдад маш их уурлаж ингэж хэлэв.

“Миний гэр бол бүх үндэстний залбиралын гэр. Та нар юунд Бурханы сүмийг дээрэмчдийн үүр болгоно вэ?”

Есүс бүх худалдаачдыг сүмээс хөөж гаргав. Үүнийг харсан фарисайчууд болон хуулийн багш нар Есүсээс эмээв.

Олон хүмүүс Есүсийн зааж байсан сургамжийг дагаж байсан учраас тэр юм.

Бурханы үгийг тайлбарлан дамжуулах нь өөрсөдтэй нь адил, боловсорсон өндөр түвшиний хүмүүс л хийж чадах ажил гэж бодож байв.



Бүтээлч байцгаая 1. Доорх асуултад хариулаарай.

а. Иерусалимд ямар баяр тэмдэглэдэг байсан бэ?

б. Шавь нар нь ямар амьтан авчирсан бэ?

с. Есүсийг Иерусалимд орж ирэхэд хүмүүс Есүсийг хэрхэн хүлээж авсан бэ?

● Дараах ишлэлийг уншаад цээжлээрэй. (Марк11:10)

**Эцэг Давидын маань айсуй хаанчлал ерөөлтэй еэ! Хамгийн дээдэд Хосанна!
гэж хашхиралдаж байлаа.**

